



ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ БОЛОВСРОЛ
ШИНЖЛЭХ УХААНЫ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 12 сарын 25 өдөр

Дугаар 4/70

Баян-Өндөр сум

Ёс зүйн дэд хороо байгуулах тухай

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.2 дахь заалт, Боловсролын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.11 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор Ёс зүйн дэд хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Дэд хорооны дарга:

Ц.Лхагвасүрэн (Нийгмийн ухаан сургалтын арга зүй, гүйцэтгэлийн үнэлгээ хариуцсан мэргэжилтэн)

Гишүүд:

Ч.Биндэръяа (Боловсрол, шинжлэх ухааны хяналтын улсын ахлах байцаагч)

Д.Эрдэнэжаргал (Дүрслэх урлаг, зураг зүй, технологийн сургалтын арга зүй, гүйцэтгэлийн үнэлгээ хариуцсан мэргэжилтэн)

Д.Энхцэцэг (Шинжлэх ухаан, технологи, инноваци, дээд боловсрол, мэргэжлийн боловсрол хариуцсан мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга:

Д.Эрдэнэчимэг (Сургуулийн өмнөх боловсрол хариуцсан мэргэжилтэн)

2. Хуулийн хүрээнд бүрэн эрхээ шударгаар хэрэгжүүлэн үүрэгт ажлаа хариуцлагатай гүйцэтгэхийг Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүдэд даалгасугай.

ДАРГА О.АРИУНГЭРЭЛТ

